

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 01 ДҮГЭЭР ЗАХИРАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН
ЗДТГ, СОЁЛЫН ТӨВ, ХҮН ЭМНЭЛЭГ, ЕБС, ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСИЙН ЗОХИОН БАЙГУУЛСАН
АЖЛЫН ТАЙЛАН**

Засаг даргын тамгын газар			
№	Хийгдэх бүтээлч ажил	Хэрэгжилт	Хувь
1	Сумын төвд байрлах 12 айлын орон сууцыг засварлах	Аймгийн Орон нутгийн хөгжил сангаар хийгдэх ажлын 2019-2020 оны төлөвлөгөөнд 12 айлын орон сууцыг засварлах саналыг ХОХБТХ-т хүргүүлсэн.	40
2	Байгууллагын засварын ажлыг хийх.	ЗДТГ-нь бороо гоожиж, өрөө тасалгаа чийгтэй, хүйтэн ажиллах нөхцөл хүндрэлтэй байсан. 2020 оны 11 сард “Ашид бюлдинг” ХХК нь ЗДТГ-ын дээврийг бетонон цутгалт хийж чийгний хамгаалалттай хар лак түрхэж, хар цаас дэвсэж шинээр дээврийн усны хаялга хийсэн. Бусад өрөө тасалгааг засварлах боломж нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн гадна хаалга вакуум хаалгаар сольж дулаан алдагдал багассан. Төсөвт өртөг 70.000.000 төгрөг. ЗДТГ-ын гадна хашааг сольж шинэчилсэн.	100
3	Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх явган хүний зам тавих	Иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумын гэр хороолол, лагерьт 12 цамхаг буюу 60 гэрэл, мөн 2 километр замын 70 ширхэг шонгийн 140 ширхэг гэрэлтүүлгийг байршуулсан.	100
4	Ногоон байгууламж нэмэгдүүлэх иргэдийн санаачлагыг дэмжиж ажиллах	Сумын засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/42 тоот захирамжийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 02-ноос 16 ны өдрийг хүртэлх хугацаанд байгууллага аж ахуйн нэгж бүр 5-аас доошгүй, өрх бүр 3-аас доошгүй мод тарьж ургуулахыг уриалж Сумын хэмжээнд нийт 2020 оны байдлаар 184 хүн 1500ш модны суулгацыг тарьж суулгалаа. Үүнд ЕБС сургууль 700ш суулгац /400ш чацаргана, 200ш хайлаас 100ш шар хуайс /, Цэцэрлэг / 300ш хайлаас /, Сум дундын эмнэлэг 300ш хайлаас, Онцгой байдлын салбар 50ш хайлаас, Засаг даргын тамгын газар 50ш улиас, тус тус тариалсан ба сумын төвийн хэмжээнд нийт 5 өрх 100 ш модны суулгац /50ш цацаргана, 20 хайлаас 20 улиас 10 шар хуайс /суулгалаа.	100
5	Хүүхдийн тоглоомын талбайг засварлах ажлыг нэмэгдүүлэх	ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн Урангоогоор ахлуулсан Хамтарсан багийн гишүүд сумын төвөөр явж хүүхдүүдийн тоглох орчин нөхцөлтэй танилцаж унаж бэртэх аюултай газруудын байршлыг тогтоон холбогдох газарт хэлж булуулах, хашаажуулах арга хэмжээг авсан. ЗДТГ-ын албан хаагч нар өөрсдийн нөөц боломжид тулгуурлан Далай лагерийн хажуугийн тоглоомын	70

		талбайн хашааг будаж эвдэрсэн тоглоомыг засварлан будаж сэргээсэн. ОНХС-ын хөрөнгөөр хийгдэх ажлын саналд Жаргалант лагерьт тоглоомын талбай барих саналыг хүргүүлсэн.	
6	Камержуулалтыг нэмэгдүүлэх	ОНХС-ын хөрөнгөөр сумын нийтийн эзэмшлийн талбайн хяналт шалгалтыг сайжруулах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 360 градус эргэдэг 5 ширхэг, чиглэлийн 3 ширхэг камерыг шинээр суурилууллаа. Нийт 12 камертай болсон. Гүйцэтгэгч: "Эйр тауэр" ХХК Төсөвт өртөг: 10.000.000 төгрөг	100
7	Усан хангамжийг нэмэгдүүлэх цахим худагтай болох	Төрийн албан хаагч болон иргэдийг цагт баригдалгүй хүссэн үед ундны усаа авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн. ОНХСын хөрөнгөөр "Крандхолдинг" ХХК нь Угтаал лагерийн худгийг цахим худаг болгох ажлыг гүйцэтгэсэн. Төсөвт өртөг нь 9.900.000 төгрөг.	100
8	Цэвэр бохир усны шугамд холбогдох	Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр Цэвэр усны 3км, бохир усны 3 км шугам сүлжээ тавигдаж 50 м ³ цэвэрлэх байгууламж баригдах ажлын зураг төсөл хийгдсэн. Зураг төсөл нь Азийн хөгжлийн банканд хянагдаж байна.	40
9	Хатуу хучилттай 2 км зам ашиглалтанд оруулах	Хатуу хучилттай 2 км зам нь бетон хучилт хийгдэж байгаад 11 сард зогссон. Гүйцэтгэл 40 хувьтай байна.	40
10	Шинээр үүссэн лагерь хороололд эрчим хүч татах	Шинээр үүссэн лагерь хороололд эрчим хүч татах ажил 2020 онд хийгдээгүй.	-
	Нийт	Хувь	69

Соёлын төв			
№	Хийх ажил	Хэрэгжилт	Хувь
1	Ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах 2 өрөөний засвар тохижилт хийх	Хөгжмийн кабинетын таазыг зориулалтын материал бүхий наадаг тааз хийж, өрөөний гэрэл хөшиг зэргийг шинэчиллээ. Мөн техникчийн өрөөг дээш өндөрлөн, шат хийж стандартын дагуу тохижууллаа. /345 000 төгрөгийн засвар үйлчилгээ хийгдсэн/ Хөгжмийн кабинетын таазыг 7-р багийн иргэн Ж.Оюунмаа, Л.Хулан нарын 120 000 төгрөгийн хандиваар хөөсөнцөр хавтангаар доторлолоо. Номын сангийн уншигчдын 10 сандлыг бүрээслэж, уншигчдын унших боломж нөхцөлийг сайжруулах зорилгоор 6 гэрэлтүүлгийг нэмж байршууллаа.	100

2	Номын санд “Ардын өв уламжлал зан заншил” –ын булан бий болгох	Номын санд “Ардын өв уламжлал зан заншил” –ын булан бий болгох зорилгоор ажилчдын дунд уралдаан зарлаж , уламжлалт “Шагайн наадгайн булан, “Монгол ёс заншил” зэрэг 2 буланг дотоод нөөц бололцоо ашиглан тохижууллаа.	100
3	Ажилчдын амралтын өрөөг бий болгон тохижуулах	Кассын өрөөг ажилчдын амралтын өрөө болгон тохижуулж, ус буцалгагч, буйдан, аяга тавагны шүүгээ зэргийг байрлуулсан.	100
4	Ажилчдыг ажлын дүрэмт хувцастай болгох	Ажилчдыг дүрэмт хувцастай болгох зорилгоор дотоод нөөц бололцоог ашиглан үндэсний хэв загвар бүхий хантааз 5 ширхэгийг хийсэн.	100
5	Ажилчдыг хөрвөх чадварт сургах ажлын байрны сургалтыг тогтмолжуулах	Ажилчдыг хөрвөх чадварт сургах зорилгоор компьютерийн анхан шатны сургалтыг эрхлэгч Ө.Эрдэнэчимэг ажилчдад 6 удаа, морин хуур, үндэсний хөгжмийн сургалтыг 5 ажилтанд хөгжмийн багш Б.Адъяацэнд 7 хоногт 1 удаа, номын сангийн стандарт арга зүйн сургалтыг номын санч Б.Оюунчимэг 3 удаа тус тус зохион байгуулсан.	100
6	Нийт	Хувь	100

Зорилго: Ажиллагсадын ажлын байрны болон өөрсдийн амьдрах орчинг сайжруулахад оршино.

Ерөнхий боловсролын сургууль			
Д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
1	Цамхагт гэрэл шинээр хийх	Сургуулийн хашаанд цамхаг гэрэл тавих, цагийн реле, гэрлийг авч бэлтгэн бэлэн болгосон. Одоо гэрлийн шон татах, байрлуулан холболт хийх ажил үлдсэн. Хичээл сургалт эхлэхээр холбоно.	70
2	Чийрэгжилтийн танхим бий болгох	Сургуулийн 90 жилийн ойг угтан төгсөгчдийн хандиваар хийгдэх байсан ажиллууд ой хойшилсонтой холбогдон 2021 онд хийгдэхээр болсон.	-
3	Склад устган хог зайлуулж аж ахуйн хашааг засварлах	Складны хог шороог бүрэн цэвэрлэж, хог хаягдлыг зайлуулан, хашааг засварласан. Сумын өмч хамгаалах зөвлөлөөс эд хөрөнгө складны эмх цэгц бүртгэлд хяналт үнэлгээ дүгнэлт хийсэн./ хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг явуулж, хүн бүртэй бүрэн хариуцлагын гэрээ байгуулсан.	100
4	5-н айлын дүнцэн байшин барих	Төрийн албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллуулах, амьдрах орчин орон сууцаар хангах үүднээс гэрээгээр 4 айлын өвлийн сууц бариулж 3 айл нь бүрэн барьж орсон.	70

5	Хуучин гал тогоог автомашины граж болгох	Хуучин гал тогоог авто машины граж болгох саналыг аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн. Хариу мэдэгдэл авсаны дараа ашиглалтыг өөрчлөн автомашины граж болгон ашиглана. / гражын хаалга хийх төмөр нугасны асуудлыг шийдсэн.	40
6	Нүүрсний сав буулгаж цэвэрлэх	Хуучин нүүрсний савыг буулган цэвэрлэж, хог зайлуулах цэгт ачин устгал хийсэн.	100
7	Тарьсан модыг хашаажуулах гадна засмал зам тавих зүлэгжүүлэх сүүдрэвч	Орон нутгийн хөгжлийн сангийн 9,8 сая төгрөгөөр явган хүний зам тавьж 4 сүүдрэвч усан сан бүхий тохижилтийн ажил хийгдэн сумын комисс хүлээн авсан. Шинээр 1000 гаруй мод тарьж арчилгаа, тордолтыг хийн ургуулж байна.	100
8	Зочид буудал, багш нарын байр засварлах	Сургуулийн 90 жилийн ойг угтан төгсөгчдийн хандиваар хийгдэх байсан ажиллууд ой хойшлосонтой холбогдон 2021 онд хийгдэхээр болсон.	-
9	Хогийн цэг, гадна бие засах газар сайжруулах	Хуучин В байрны орчинд байсан хогийн блокон хогийн цэгийг буулган авч бусад гадна нойлыг засварлан будсан.	100
10	Байрны гал тогооны халаалт, дулааныг сайжруулах (байрны гадна тал дулаалах)	Дотуур байранд аймгийн хөгжлийн сангийн 116,08 сая төгрөгийн хөрөнгөөр дотор засварын ажил хийгдэж байна. Гадна дулаалга хийх төсвийн саналыг БСШУЯ-нд хүргүүлсэн, нэгдсэн халаалтын компани гал тогооны дулааныг сайжруулах битүүлсэн турбан солих зорилгоор 200 метр турбан ирүүлсэн.	70
11	440, дотуур байрыг засварлах	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 170 сая төгрөгөөр их засварын хөрөнгө батлагдан хийгдэх байсан боловч БСШУЯ бүх хөрөнгийг 100 царцаасан учир хийгдээгүй.	-
12	Өргөө гэрийн мод засварлах шинэ бүрээс, туургатай болох	Сургуулийн өргөө гэрийн модыг будаж засварлан барихад бэлэн болгосон. Гэрийн бүрээс хандив тусламжийн хүрээнд шийдэхээр хөөцөлдөж байна.	40
13	Урлаг зал сандалтай болгох	Сургуулийн 90 жилийн ойг угтан төгсөгчдийн хандиваар хийгдэх байсан ажиллууд ой хойшилсонтой холбогдон 2021 онд хийгдэхээр болсон.	-
14	Биеийн тамирын заланд хувцас солих өрөөтэй болох тохижуулах	2 биеийн тамирын заланд хувцас солих өрөө гарган бэлтгэсэн.	100
15	5 хүртэлх ангийн ширээ сандлыг шинэчлэх	Ажилчдын өөрсдийн хүчээр 3 ангийн олон улсын байгууллагын хандиваар 1 ангийн ширээ сандлыг 100% шинэчилсэн.	100
16	Цахилгаан хөгжмийн хамтлаг бий болгон сургалт явуулах	Сургуулийн 90 жилийн ойг угтан төгсөгчдийн хандиваар хийгдэв. Төгсөгч Б. Чинзориг тэргүүтэй 1999 оны төгсөгчид даралтат хөгжим, цахилгаан гитар, ком өсгөгч зэрэг хэрэглэгдэхүүнийг өгсөн	100
17	Сургуулийн түүхийн тохимол бичих	Түүхийн тохимол эмхтгэл бичих ажлын хэсгийг томилсон. Материалыг цуглуулан эмхтгэл бичин хэвлэхэд хэвлэлийн зардал хандиваар хийгдэх тул	40

		сургуулийн ой той холбогдон хүлээгдэж байна.	
18	Багш нарт оёдол эсгүүрийн талаарх сургалт байгуулах	Багш нарыг ажлын байрны хувцастай болох зорилгоор технологийн багш нар ахлан оёдол эсгүүрийн сургалт зохион байгуулж явуулсан.	100
	Нийт	Хувь	62.7

Сум дундын эмнэлэг			
№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
1	Шинээр ажилд орж байгаа болон залуу боловсон хүчнээ амьдрах орчин нөхцөлөөр хангах	Шинэ эмнэлгийн больниц, амбулатори хосолсон эмнэлэг баригдаж ашиглалтад орж үйл ажиллагаагаа явуулж байна. Хуучин эмнэлгийн барилгыг эрүүл мэндийн төвд ирж ажиллах залуу боловсон хүчин болон өөрсдийн зарим нэг ажилчдыг орон байраар хангах зорилгоор ашиглаж ЗДТГ-ын ХАА-н тасгийн тархвар судлаач мэргэжилтэн 1 хүн, СДЭ-ийн 2 эмчийг оруулсан боловч улсын онцгой комиссын шийдвэрийг харгалзан коронавируст халдвар Ковид-19-ийн цар тахлын тархалттай холбоотойгоор барилгыг тусгаарлах байр болгон бэлдэж , айлыг нүүлгэн шилжүүлээ. Цаашид эмч ажилчдын орон байрны асуудалд дэмжлэг үзүүлэхэд ашиглах зорилготой байна.	100
2	Ажилчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлэх	Засгийн газрын 382 дугаар тогтоолын дагуу үр дүнгийн урамшууллыг улиралд нэг удаа олгож нийт 22896653 төгрөг, албан хаагчдад сар бүр олгодог хоол хөнгөлөлт ,унааны зардлыг өдрийн 1000 төгрөг, аймагт албан томилолтоор 14000 . УБ хотод томилолтоор16000, сумдад 12000 төгрөгөөр тооцож 6119000, Ковид-19 цар тахлын бэлэн байдалд ажиллаж байгаа албан хаагчдад дархлаа дэмжих зорилгоор 1550000 төгрөг, ур чадварын нэмэгдлийг 12 хүнд 7918858 төгрөгийг тус тус олгосон. СЗД-ын Жуух бичгээр 4 хүн шагнагдсан.	100
3	Ажилтан албан хаагчдаа ажиллах орчин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах	Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хандиваар өргөгчтэй ор 400,000 төгрөг, EpsonL3110маркийн принтер 1 ширхэг /417,900 төгрөг/, өвчтөний монитор 1 ширхэг /3,800,000 төгрөг/, зөөврийн компьютер 1 ширхэг /1,450,000 төгрөг/, хүлээлгийн сандал 2 ширхэг 800,000төгрөг, кушетка 128,000 төгрөг, эргэдэг сандал 70, 000төгрөг, зөөврийн хүчилтөрөгч 1,250,000 төгрөг, пакетлагч 450,000 төгрөгөөр авч нийт 8,165,900 төгрөгийн эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг авсан байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	100

		37,900,000 төгрөгний үнэтэй пургон автомашиныг аваад байна.	
4	Эрүүл мэндийг дэмжигч айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулж, шагнаж урамшуулах	Шалгаруулалтыг 2 удаа хийлээ. 5-р багийн иргэн М.Галбадрах эмэгтэйчүүдийн тасагт Lenovo фирмийн зөөврийн компьютер хандивлаж эрүүл мэндийг дэмжигч айл өрхөөр шалгарлаа. Шинэ эмнэлгийн барилга ашиглалтад орсонтой холбогдуулан Эрдэнэдалай сумын ерөнхий боловсролын сургуулийн 1989 оны төгсөгчид хүчилтөрөгчийн зөөврийн аппарат, ширээний даралтын аппарат, пульс оксиметр 1, удаагийн маск 500 ширхгийг хандивлаж эрүүл мэндийг дэмжигч шилдэг байгууллагаар шалгарлаа.	100
5	Эмч, мэргэжилтнүүдийг сурах, мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Хүний нөөцийн 3 жилийн судалгаатай 5 жилийн төлөвлөгөөтэй ажиллаж байна. 2018 оноос “ дотор судлал”-ын нарийн мэргэжлийн их эмчээр Б.Ган-Эрдэнэ суралцаж төгсөөд 2020 оны 11 сард эмнэлэгтээ дотрын эмчээр ажиллаж эхэллээ. Сумын засаг даргын дэмжлэгтэйгээр Г.Отгонсүх, Г.Урангоо нарыг “ Глобаль удирдагч” дээд сургуульд сувилагчийн мэргэжлээр 2018 оноос суралцуулж байна. 2019 оноос “ Мэс засал судлал”-ын нарийн мэргэжлийн их эмчээр М.Билгүүн, “ Хүүхэд судлал”-ын нарийн мэргэжлийн их эмчээр Ө.Мягмарсүрэн, 2020 онд “Хүүхэд судлал”-ын нарийн мэргэжлээр их эмч Б.Дуламсүрэн нар суралцаж байна. Хүний нөөцийн төлөвлөгөөний дагуу бага эмч М.Өлзиймаа нь Дорноговь аймаг дахь АШУҮИС-д 1,5 жилийн эм найруулагчаар, лаборант Д.Амарбаясгалан УБ хотод Улсын клиникийн төв нэгдүгээр эмнэлэгт “Сереологи лаборант”-ын 3 сарын сургалтанд тус тус танхимын сургалтаар суралцаж байсан боловч, улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу онлайнаар сургалтад хамрагдаж байна . 2020-2021 оны хичээлийн жилд суралцах төгсөлтийн дараах сургалтын захиалга өгсний дагуу Г.Манлажав “ Нярайн яаралтай тусламж”-ийн 3 сарын олгох курс, бага эмч А.Оюунчимэг “ Зонхилон тохиолдох хүүхдийн өвчин”-ий тусламж үйлчилгээний 2 сарын мэргэжил дээшлүүлэх курст тус тус суралцаж төгссөн.Нярав Д.Цогтбаяр УБ хотод НЭМҮТ-д няравын мэргэжил дээшлүүлэх ,тогооч Э.Чулуунцэцэг тогоочийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг тус тус дүүргэсэн. Сул орон тооны мэдээллийг сар бүрийн 25-нд аймгийн эрүүл мэндийн газрын хүний нөөцийн албанд мэдээлж байна. 5-р багийн эмчийн түр орон тоонд тэтгэвэр тогтоолгон ажиллагч эх баригч бага эмч Ууганбаяр ажиллаж байна. 6-р багийн эмчийн сул орон тоо гарсан тул бага эмч М.Өлзиймаа хавсран ажиллаж байна. Ерөнхий эмч Д.Батцэцэг, УАУ-ны бага эмч Ж.Мягмарсүрэн нар хүүхэд асрах чөлөөтэй байж байгаад үүрэгт ажилдаа томилогдон	70

		ажиллаж байна. 2020онд ерөнхий мэргэжлийн эмчээр шинэ төгсөгч Б.Дуламсүрэн эмч ажилд томилогдон орсон боловч “Хүүхэд судлал”-ын нарийн мэргэжлээр суралцахаар явсан.	
6	Иргэдийн дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийн судалгааг гаргах, дүгнэлт хийх	Сумын хэмжээнд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчлөлүүдийг тэргүүлэх 5 өвчлөлөөр авч үзвэл: Зүрх судасны өвчлөл Амьсгалын замын өвчлөл Шээс бэлгийн замын өвчлөл Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл Эдгээр өвчлөлийн судалгаан дээр үндэслэж хэвтэн эмчлүүлсэн болон амбулаториор үйлчлүүлсэн иргэдийн мэдээлэлд түүврийн аргаар судалгаа хийж , судалгаанаас гарсан дүгнэлтээс -зөв зохистой хооллолт -Идэвхтэй дасгал хөдөлгөөн -Эмийн бус эмчилгээний арга зөвлөж ажиллалаа. Үе мөч, яс булчингийн эрхтэн тогтолцооны өвчлөл эзэлж байна. 2020 онд 25 халдварт өвчлөл бүртгэгдсэнээс тэмбүү 19, салхинцэцэг 1, улаан эсэргэнэ 1, сүрьеэгийн 2 , хачигт халдвар 1,тохиолдол бүртгэгдээд байна.	100
7	Иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх	Артерын даралт ихсэх өвчин / АДИӨ/-ий илрүүлэг үзлэгт 1312 хүн хамрагдахаас 967 хүн хамрагдаж 73,7%. Артерийн даралт ихсэх өвчний илрүүлэг үзлэгээр байж болзошгүй эрсдэлтэй 28 иргэнийг давтан үзлэгээр хянаж, шинээр АДИӨ-ий 26 тохиолдол илэрч хяналтанд авч эмийн болон эмийн бус эмчилгээг зөвлөж байна. ЧШӨ-ий илрүүлэг үзлэгт 1510 хүн хамрагдахаас 1065 хүн хамрагдаж 70,5%-тай, шинээр ЧШӨ 2 хүн илэрч эмийн эмчилгээтэй эмчийн хяналтанд байна. Умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг үзлэгт зорилтот насны 357 эмэгтэй хамрагдахаас 239 хамрагдаж 67,0%, хөхний өмөнгийн илрүүлэгт 1501 эмэгтэй хамрагдахаас 1050 эмэгтэй хамрагдсан 69,9%/ байна. Умайн хүзүүний хавдрын урьдал оношоор 3 эмэгтэй илэрч хяналтаар давтан шинжилгээнд хамрагдаад байна. 1 эмэгтэй умайн хүзүүний өмөн оношоор хагалгаанд орж эмчлэгдсэн. Элэгний В,С вирусийн шинжилгээнд давхардсан тоогоор 543 хүн хамрагдаж “В” вирустэй 33, ” С” вирустэй 32 хүн илэрч эмчийн хяналтанд байна. Үүнээс “Элэг бүтэн монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд элэгний илрүүлэг үзлэгт	70

		<p>2020 онд 2672 хүн хамрагдахаас 104 хамрагдаж шинээр “С” вирустэй 7, “В” вирустэй 11 хүн илэрч хяналтанд авлаа. Вирустэй иргэдийг цахимаар бүргэж ачаалал тоолуулах лабораторит илгээж ажиллаа. ЭМДЕГ буюу Дундговь аймгийн ЭМД тасагтай Багцын урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээ хийсний дагуу зорилтод насныханд БЗХӨ, хэвлийн эхо, зүрхний цахилгаан бичлэгийн үзлэг, оношлогоо шинжилгээг 220 хүнд хийж 2532000 төгрөгний санхүүжилт нэхэмжилсэн.</p>	
8	<p>Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн, сурталчлан өнгөрүүлэх</p>	<p>Осол гэмтлээс сэргийлэх сарын хүрээнд амбулатори, больницоор үйлчлүүлж буй иргэдэд ахуйн осол гэмтлээс хэрхэн сэргийлэх, ахуйн осол гэмтлийн өнөөгийн байдлын талаарх тоон мэдээ, осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх мэдээ, мэдээллээр хангах зорилгоор “Ахуйн осол гэмтлээс сэргийлье” сэдэвт сургалтыг 30 иргэнд хийж мэдээлэл сурталчилгааг хүргэлээ. Энэхүү сургалтанд 52,200 төгрөгийг зарцууллаа. Сургалтаар ахуйн осол гэмтлийн шалтгаан, нөхцөл байдал, ахуйн осол гэмтлээс хэрхэн сэргийлэх вэ?, түлэгдэлт, анхны тусламж, халтиргаа, гулгаанаас хэрхэн сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг өглөө.</p> <p>Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр “Ахуйн осол гэмтлээс хэрхэн сэргийлэх вэ”, “Халтиргаа, гулгаанаас сэргийлье”, “Замын хөдөлгөөнд соёлтой оролцъё”, “Түлэгдэлт ба эцэг эхийн оролцоо” сэдвээр зайн мэдээлэл хүргэлээ.</p> <p>Сумын цагдаагийн хэсэгтэй хамтран зам тээврийн осол гэмтлээс үүдэлтэй аюул, хор хөнөөл түүнээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигч болон жолооч нарт замын хөдөлгөөнд болгоомжтой оролцох, зам тээврийн осол гэмтлээс хэрхэн сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг өгч гарын авлага, материал тараалаа.</p> <p>Сумын аж ахуйн нэгж, байгууллагуудад ахуйн осол гэмтлээс сэргийлэх, зам тээврийн хөдөлгөөнд зохистой, соёлтой оролцох, халтиргаа, гулгаанаас сэргийлэх талаар зөвлөмж мэдээллийг өгч, гарын авлага, мэдээллийг тараалаа.</p> <p>Ахуйн осол гэмтлээс сэргийлэх зөвлөгөө мэдээллийг байгууллагын цахим хаягндаа байршуулж ажиллалаа.</p> <p>Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан сургалт, сурталчилгааны сэдэвчилсэн төлөвлөгөөний “Архидан согтуурахаас сэргийлье” тэмдэглэлт өдөр, аймгийн Засаг даргын 2018 оны А/231 дүгээр захирамжаар батлагдсан “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Архигүй гэр бүл” уриан дор хүн амын дунд архи согтууруулах ундааны хор уршиг, түүнээс сэргийлэх мэдээлэл</p>	100

сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллалаа. Амбулаториор үйлчлүүлсэн 143 иргэн, хэвтэн эмчлүүлж буй 18 иргэнд архины хор хөнөөл, уршгийн талаар мэдээлэл зөвлөгөөг өглөө. Мөн орон нутгийн fm-ээр 2 удаа архины хэрэглээ, хор уршгийн талаар сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэж ажиллалаа. Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ний өдрийн А/68 тоот тушаалаар архи согтууруулах ундааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл худалдан борлуулахыг хориглосон шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаж байна. Байгууллагын face хуудсаар хор уршгийн талаарх мэдээллийг байршуулсан.

“Сүрьеэ өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийг энэ жил “Дэлхий нийтээрээ сүрьеэ өвчнийг устгах амлалтаа биелүүлэх цаг нь боллоо, арга хэмжээ авах цаг нь боллоо” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн. Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын цахим хуудсанд 5 удаа 6 төрлийн мэдээллийг байршуулж зөвлөгөө мэдээллийг хүргэж ажилласан. Сүрьеэгээс сэргийлэх мэдээллийн самбарыг байршуулж, мэдээллийн буланг ажиллуулж байна. Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр сүрьеэ өвчин, сүрьеэ өвчний халдвараас сэргийлэх мэдээллийг 2 удаа хүргэн ажилласан. Амбулаториор үйлчлүүлж буй 64 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 192 ширхэг материалыг тараасан байна.

“Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх” аяны хүрээнд байгууллагын цахим хаяганд 3 удаагийн 7 төрлийн мэдээллийг байршуулж, амбулаториор үйлчлүүлж буй 45 иргэнд ахуйн осол гэмтлээс сэргийлэх зөвлөгөө мэдээллийг өгч 135 ширхэг тараах материалыг тараасан.

“Таны худалдан авдаг хүнсэнд хэр зэрэг их давс нуугдаж байгааг мэдэх үү?” мэдээлэл сурталчилгааны 7 хоногийн хүрээнд байгууллагын фасебүүк хаяганд 3 удаагийн 3 төрлийн мэдээллийг байршуулж, мэдээллийн самбарт холбогдох мэдээллийг байрлуулж, амбулаториор болон хэвтэн эмчлүүлсэн 21 иргэнд давсаа баг хэрэглэх, хүнсний бүтээгдэхүүнд давс хэр агуулагдаж байдаг, давсны эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээллийг өгч 63 ширхэг тараах материалыг тараасан байна.

“Эко сав элэг бүтэн амьдрал” мэдээлэл сурталчилгааны 7 хоногийн хүрээнд 3 удаагийн 15 мэдээллийг байгууллагын фасебүүк хуудсанд байршуулж, амбулаториор үйлчлүүлж буй 70 иргэнд 140 ширхэг тараах материалыг тараасан байна.

Чихрийн шижин, Хавдраас сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын эсрэг анхаарлаа

		<p>хандуулах өдрийг тохиолдуулан байгууллагын цахим хаягаар мэдээлэл зөвлөгөөг өгч ажиллаж байна.</p> <p>Дэлхийн алхалтын өдрийг тохиолдуулан албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд “Алхангаа ярилцъя” арга хэмжээг зохион байгуулж 74 хүн хамрагдсан.</p> <p>Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх мэдээллийг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газраас ирсэн зөвлөмж мэдээллийн дагуу хүргэж ажиллаж байна. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээллийг байгууллагын файсбүүк хаягаар 312 удаа 312 мэдээллийг , орон нутгийн fm-ээр 64 удаа мэдээллийг цаг алдалгүй хүргэж, аж ахуйн нэгж, байгууллагаар сурталчлан ажилласан.</p>	
9	Нүхэн жорлонг ариутгах цэвэрлэх арга зүйн зөвлөгөө өгөх	Амбулаториор үйлчлүүлсэн 148 иргэнд нүхэн жорлонг ариутгах заавар зөвлөгөөг өгч тараах материалыг тараасан байна. Ариутгагч бага эмч М.Уртнасан 80 айл өрхийн нүхэн жорлонд ариутгал хийсэн. Мөн гэрийн ажиглалт, тусгаарлах байранд байгаа иргэдийн нүхэн жорлонг ариутгаж халдваргүйтгэсэн.	70
	Нийт	Хувь	90

ЗОРИЛГО: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 01 ЗАХИРАМЖИЙН ХҮРЭЭНД БАГШ АЖИЛЧДЫН АЖИЛЛАХ, АМЬДРАХ ОРЧИНГ САЙЖРУУЛЖ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИЖ АЖИЛЛАНА /ЦЭЦЭРЛЭГ/

№	ХИЙГДЭХ АЖЛУУД	ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН	
НЭГ: АЖИЛЛАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
1.1	Ахлах, Бэлтгэл камержуулах шийдвэрлэх бүлгийг асуудлыг	Цэцэрлэгийн камерийн шинэчлэлийн ажил хийгдэж хуучин аналог 15 камертай байсан бол одоо IP 21 камертай болж, ахлах бэлтгэл ангиудын, унтлагын өрөө, хүлээн авах өрөө, шат, коридорууд, цэцэрлэгийн хойд тал , урд тоглоомын талбай, машины зогсоол бүгд бүрэн камержлаа.	100
1.2	150 хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэх сайжруулах засвар	Дотоод нөөц бололцоогоо ашиглан жижиг засвар үйлчилгээг цаг тухай бүрд нь хийж байна	70

	үйлчилгээ хийх		
1.3	Эмчийг тусгай өрөөтэй болгож шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслэлээр хангах	Хүүхдийг болон багш ажилчдаа өвчнөөс урьдчилан сэргийлэх эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор тусгай өрөөг тохижуулан засвар хийж дуусгалаа. Аймгийн МХГ-аас өгсөн шаардлагын дагуу бүлэг бүр эмийн сантай болж 10 бүлгийн эмийн санд 5 төрлийн 388,000 төгрөгний зүйлийг хийж өглөө.	100
1.4	Ангийн хүүхдүүд ном үзэж ярилцах “Номын өрөө”-тэй болох тохижуулах	“Ёс заншлын өргөө”-нд анги бүлгүүдийн хүүхдэд зориулсан тусгай ширээ сандал бэлтгэж “Номын өргөө”-г байгуулж хүүхэд бүрийг ном үзэх боломжыг бүрдүүдээд байна.	100
1.5	Аяга угаах өрөөг тохижуулж стандартын дагуу 3 дамжлагаар угаах	Ахлах Бэлтгэл бүлгүүдийн хүүхдийн аяга угаах өрөөг тусгаарлан байгуулж ариун цэврийн шаардлага хангасан өрөөг тохижуулж байна. дотоод нөөц бололцоогоороо тохижуулж дуусгасан. 100% гүйцэтгэлтэй.	100
1.6	Хүнсний ногоо тарих, “Хүлэмж”-тэй болох асуудлыг шийдвэрлэх	Тогооч нар хүүхдийг туршлагын талбайд ажиллуулах зорилгоор төмс чацаргана тарьж Бэлтгэл А,Б,В бүлгийн хүүхдүүд тогооч нарынхаа тарьсан төмсийг хураан авч, чацарганаа жимстэй танилцан нийт 15 кг төмс хураан авлаа.	100
ЦЭЦЭРЛЭГИЙН ГАДНА ОРЧНЫГ ТОХИЖУУЛАХ ШИНЭЭР ХИЙХ АЖЛЫН ЖАГСААЛТ			
1.7	Гадна камерийн тоог нэмэгдүүлж хяналтыг системийг сайжруулах	Гадна камержуулалтыг бүрэн хийж тоглоомын талбай цэцэрлэгийн орчинд 5 газарт камертай боллоо.	100
1.8	Ангиудын цэцгийн мандлын тоог нэмэгдүүлж цэцгийн нэр төрлийг олшруулах	Анги бүлэг бүр бүлэг өрөө тасалгаандаа ангид байх тасалгааны цэцэгийн тоог нэмэгдүүлж нийт 122 цэцэгтэй болоод байна. 10 бүлэг 10 ширхэг, Гал тогоо 2 ширхэг арга зүйч, дуу хөгжмийн багш нар тус бүр 1-2 цэцгийн мандал бүгд 16 ширхэг цэцгийн мандалд төрөл бүрийн цэцэг тарьж арчилж ургуулж байна.	100
1.9	Хүүхдийн гадна тоглоомын тоог нэмэгдүүлж, өнгө будгийг сэргээх	Гадаа тоглоомын өнгө будаг сэргээж чадаагүй	0
1.10	50 хүүхдийн цэцэрлэгийн байрны “Дээвэр засвар”-ын ажлыг хийлгэж дулаан алдалтанд анхаарч ажиллах	1982 онд ашиглалтанд орсон 50 хүүхдийн цэцэрлэгийн байрны “Дээвэр засвар”-ын ажлын зураг төсвийг хийлгэж бэлэн болгоод Аймгийн БСУГ болон Аймгийн хөгжлийн бодлогын газар хүргүүлсэн.	40
ХОЁР: АЖИЛЧДЫН АМЬДРАХ ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
2.1	Ажилчдыг эпотекийн зээлд хамруулж орон сууцжуулах	Одоогоор хамрагдаагүй	0

	асуудлыг судлах		
2.2	Хувийн орон сууц барих цалингийн зээл олгох асуудлыг шийдвэрлэх	Энэ 2020 онд байшин барих зээл 1 туслах багшид олгосон	70
2.3	Амралтаараа ажил эрхлэх боломжийг судлах ажлын цагийн асуудлыг шийдвэрлэх	Хамт олны идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх ,чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилготой "Эрдэмд дусал нэмэр" уриан дор багш, ажилчдын дунд "Залуусын холбооноос" санаачилж #Алтан хонх танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж оюун ухаан авхаалж самбаагаа дайчилан хамт олноо манлайлж, Тэргүүн байранд багш Ш.Цэцэгмаа, Дэд байранд тогооч Э.Эрдэнэцэцэг, Гутгаар байранд т.багш Ц.Оюунсүрэн нар тус тус шалгарлаа	100
2.4	Эрүүл мэндийн үзлэгт хамруулах,эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	Бүх багш ажилчдаа 9 сард Аймгийн нэгдсэн эмнэлэгт бүх нарийн мэргэжлийн эмчид 34 багш ажилчдыг үзүүлж эмчилгээ шаардлагатай 8 хүнийг сумын эмнэлэгт ээлж дараагаар эмчлүүлж эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж одоогийн байдлаар 3 хүн эмчлүүлж гараад байна .	100
2.5	Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулан төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	Ажилчдын дунд жил бүр зохион байгуулдаг шилжин явах цомтой "ГАР БӨМБӨГИЙН "тэмцээн амжилттай болж 1-р байрыг Б.Саранхүү ахлагчтай баг, 2-р байрыг Р.Дашмаа ахлагчтай баг хамт олон эзэллээ. Тэмцээнийг ивээн тэтгэсэн "Далайн хишиг" ХЭАА-н захирал Далхсүрэн ивээн тэтгэлээ. Багш ажилчдыг 7 хоног бүрийн Лхавга гаригт ажлын байрны 2 төрлийн хөгжимт дасгалыг хийж хэвшүүлсэн. Нийт 29 багш ажилчид тогтмол хамрагдлаа . Багш ажилчдын дунд өвчлөлийн байдалд судалгаа хийж, зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлж , артерийн даралт ихсэлт , зүрх судасны өвчлөл , үе мөчний өвчлөл зонхилж байгаа учир тухайн өвчлөлөөр ангилан , тохирсон дасгал хөдөлгөөний 4 төрлийн самбар хийж, үе мөчний дасгалыг 4 хүнд, чихрийн шижин өвчнөөс сэргийлэх сунгалтын дасгалыг 2 хүнд, даралт ихсэх өвчнөөс сэргийлэх дасгалыг 5 хүнд эмчилгээний хийн дасгалыг 9 хүнд зааж хийж хэвшүүлэв. Олон үйлдэлт дижитал массажны “ Оптимум “ аппаратаар 3 хүнд эмчигээ хийснээр хүзүү хөөрч хөших зовиурьгүй болсон . Даралт ихсэлттэй 4 багш ажилтны даралтыг тогтмол хянаснаар тогтворжсон . Чихрийн шижин өвчтэй 1 багшийг хугацаанд нь саахрын 3 сарын дундаж	100

		үзүүлэх шинжилгээнд хамруулаллаа .	
2.6	Эмийн бус эмчилгээний аргыг судалж ажилдаа нэвтрүүлэх,суур өвчний онош тодруулж эмчлэн эрүүлжүүлэх	Цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө бүх багш ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 100 % хамруулав. Нийт 33 багш ажилчдыг аймгийн НЭ –ийн 17 төрлийн кабинетад зонхилон тохиолдох ХБӨ , 7 төрлийн хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж , эрүүл мэндийн эрсдэлтэй ажилтан 2, нэмэлт шинжилгээ хийлгэх 2,амбулаториор эмчлүүлэх 10, эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх 4 багш ажилчдыг ангилан , төлөвлөгөө гарган эрүүлжүүлэх ажил хийгдэж эхлээд байна . Даралт ихсэлттэй 4 багш ажилтны даралтыг тогтмол хяналаа. Багш ажилчдын БЖИ – ийг тодорхойлж , хэвийн жинтэй 13, илүүдэл жинтэй 17 , таргалалттай 3хүн байгаагаас эмчилгээний хийн дасгалд 9 хүн хамруулж эхлээд байна. В,С вирус илрүүлэх шинжилгээнд 34 / 100%/ , хеликобактери илрүүлэх шинжилгээнд 5 багш ажилчид хамрагдсан . Хеликобактери илрүүлэх шинжилгээний тест ирсэн үед бусад багш ажилчдыг хамруулахаар СДЭ – тэй тохиров.С вирустэй 1 ажилтан гарсныг дээд шатлалд вирус тоолуулахаар явуулав. Ковид – 19 халдвараас сэргийлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх чиглэлээр 2 удаа сургалт явуулав. Зөвлөлгөө зөвлөмжийг 7 хоног бүр өгч ажиллалаа.	100
2.7	Багш,Туслах багш нарын компьютерийн мэдлэгийг сайжруулах ажлын байрны сургалтыг явуулах	Ахмад багш Н.Мүнсэл үр хүүхдүүдийн хамтаар манай цэцэрлэгийн хамт олонд 4 ширхэг компьютер өглөө. Багш,Туслах багш нарын компьютерийн мэдлэгийг сайжруулах ажлын байрны сургалтыг явуулах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр 3 NOTEBOOK олгох болсон	100
2.8	Багш ажилчдыг ажиллангаа суралцах боломжийг судлах	1 туслах багш ажиллангаа “Газарчин дээд” сургуулийн СӨБ-ын багш мэргэжлээр эчнээ ангид суралцаж байна.	70
2.9	Мэргэжлийн зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлж,багшийн боловсролын зэргийг нэмэгдүүлж ажиллах	2019-2020 оны хичээлийн жилд 12 мэргэжлийн багштай болж мэргэжлийн багшаар 100% хангагдаж, мэргэжлийн зэрэгтэй багш 2019 онд 6 багш байсан бол энэ 2020 онд 10 багш ,эрхлэгч ,2 тогооч мэргэжлийн зэрэг шинээр авлаа.	100

2.10	Багш ажилчдын цалин урамшууллыг ЗГ-ын тогтоолын дагуу тогтоож нэмэгдэл хөлс,илүү цаг бусад нэмэгдлийг хуулийн дагуу олгоно	ЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоол,2019 оны 472 дугаар тогтоолын дагуу бүх багш сар бүр ур чадварын болон зэргийн нэмэгдэл зэргийг олгож,ЗГ-ын 5-р тогтоолын дагуу үр дүнгийн нэмэгдлийг олгож байна.	100
	Нийт	Хувь	82.5
	Нийт	Хувь	80.8

ХЯНАСАН:
ЗДТГ-ЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ:

Б.АМАРСАЙХАН

НЭГТЭГСЭН:
СӨГХ ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

Т.ЭРДЭНЭЗАЯА